

Монголын архетипийг хадны зургийн жишээгээр тодорхойлох нь: Визуал-семиотикийн шинжилгээнд тулгуурласан судалгаа

Бямбажавын Мэндсайхан 

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Хүнс, хөнгөн үйлдвэрлэл,
дизайны сургууль, Улаанбаатар, Монгол Улс
✉ bmendsaikhan@must.edu.mn

Дашзэвэгийн Түмэнболд 

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Хүнс, хөнгөн үйлдвэрлэл,
дизайны сургууль, Улаанбаатар, Монгол Улс

Хураангуй: Энэхүү судалгаа нь Монгол орны хадны зурагт илэрч буй дүрслэлийн хэлбэр, бэлгэдэл, утгыг семиотик ба архетипийн онолоор шинжилж, Монголын “график архетип”-ийн анхдагч илэрхийллийг тодорхойлоход чиглэв. Судалгаанд Панофскийн гурван шатлалт аргачлалыг хэрэглэж, зооморф, антропоморф, геометр хэлбэрийн морфологийн задлан шинжилгээ хийв. Үр дүнд нь монголын хадны зурагт “хүн – амьтан – тэнгэр” гурвалсан архетип давамгайл байгааг тогтоож, монголын дүрслэлийн соёлын язгуур үеийн хэлбэрийг визуал-семиотикийн аргаар тодорхойлогч зорив. Энэхүү судалгааны онолын үндэс нь архетипийн сэтгэл зүйн тайлбар, хадны зургийн танин мэдэхүйн тайлбар, дүрслэлийн иконологийн задлан шинжилгээг нэгтгэсэн хандлагад тулгуурлаж байна. Карл Густав Юнгийн архетипийн онолын дагуу хүний хамтын ухамсаргүйд орших анхдагч бэлгэдлийн бүтэц нь домог, зан үйл, урлагийн дүрслэлд давтагдан илэрдэг. Энэ үзлийг хадны зургийн судалгаанд өргөтгөн тайлбарласан Дэвид Льюис-Уильямс хадны дүрслэлүүдийг хүний танин мэдэхүйн туршлага, ялангуяа ухамсрын өөрчлөгдсөн төлөв болон шаманист зан үйлийн бэлгэдлийн илэрхийлэлтэй холбон тайлбарласан байдаг. Харин Эдвин Панофскийн иконологийн гурван шатлалын арга нь дүрслэлийн хэлбэрийг эхлээд харагдах¹ түвшинд, дараа нь бэлгэдлийн² түвшинд, улмаар соёлын гүн утгын³ түвшинд тайлбарлах боломжийг олгодог. Энэхүү судалгаанд хадны зургийн морфологийн хэлбэр, бэлгэдлийн утга, соёлын гүн бүтэц гурвыг уялдуулан авч үзэх замаар монголын дүрслэлийн язгуур дөрвөн архетипийг тодорхойлж дан

¹ Pre-iconographical description буюу “иконографийн өмнөх тайлбар” нь Эрвин Панофскийн иконологийн шинжилгээний эхний шат бөгөөд дүрслэлийн хамгийн анхан түвшний харагдах хэлбэрийг тайлбарлах үйл явц юм.

² Iconographical analysis буюу “иконографийн тайлбар” нь Эрвин Панофскийн иконологийн аргын хоёр дахь шат бөгөөд дүрслэлийн бэлгэдэл, утга агуулгыг соёлын болон түүхэн контекстийн хүрээнд танин тайлбарлах үйл явц юм.

³ Iconological interpretation буюу “иконологийн тайлбар” нь Эрвин Панофскийн аргын гурав дахь буюу хамгийн гүн түвшний шинжилгээ юм.

ганц бэлэгдлийн дүрслэл бус, харин зохион байгуулалтын тодорхой зарчим бүхий харааны систем болох бөгөөд энэ нь монголын график хэлний анхдагч хэлбэр буюу прото-визуаль⁴ систем болохыг тогтоож байна..

Түлхүүр үгс: *архетип, зооформ, антропоморф, геометр/абстракт, хадны зураг, язгуур*

Identifying Archetypal Structures in Mongolian Rock Art: A Visual-Semiotic Analysis

Mendsaikhan Byambajav 

School of Food, Light Industry and Design, Mongolian University of Science
and Technology, Ulaanbaatar, Mongolia
✉ bmendsaikhan@must.edu.mn

Tumenbold Dashzeveg 

School of Food, Light Industry and Design, Mongolian University of Science
and Technology, Ulaanbaatar, Mongolia

Abstract: This study aims to identify the primary expression of the Mongolian “graphic archetype” by analyzing the visual forms, symbols, and meanings represented in Mongolian rock art through semiotic and archetypal approaches. The research applies Erwin Panofsky’s three levels of interpretation—pre-iconographical, iconographical, and iconological—as its methodological framework and conducts a morphological analysis of zoomorphic, anthropomorphic, and geometric motifs. The analysis reveals that a symbolic triad of **human–animal–sky** predominates in Mongolian rock art, reflecting a fundamental archetypal structure of early Mongolian visual culture.

The theoretical framework of this study integrates psychological interpretations of archetypes, cognitive approaches to rock art, and iconological analysis of visual forms. According to the archetype theory of Carl Gustav Jung, archetypes are primordial symbolic structures embedded in the collective unconscious, recurring across myths, rituals, and artistic expressions. Extending this perspective to rock art studies, David Lewis-Williams interprets rock imagery as visual representations of cognitive experiences, particularly those associated with altered states of consciousness and shamanistic practices. Meanwhile, the iconological method proposed by Erwin Panofsky provides a systematic approach for interpreting visual forms at three levels: descriptive, symbolic, and cultural.

By integrating these theoretical perspectives, the study examines the morphological forms, symbolic meanings, and cultural structures embedded in Mongolian rock art in order to identify the primordial archetypal patterns underlying Mongolian visual culture.

Keywords: *archetype, zooform, anthropomorphic, geometric/abstract, rock art, etching*

⁴ Proto-visual буюу “анхдагч визуал” ойлголт нь бичиг үсэг, тогтсон дүрслэх систем үүсэхээс өмнөх үеийн хүний дүрслэлийн анхны сэтгэлгээ, тэмдэглэгээний хэлбэрийг илэрхийлдэг онолын ойлголт юм.

Оршил

Архетипийн тухай ойлголт XX зууны аналитик сэтгэл судлалын хүрээнд онолын түвшинд томъёологдсон бөгөөд хүний хамтын ухамсаргүйд орших анхдагч бэлгэдлийн бүтэцтэй холбогдон тайлбарлагддаг. Архетипийн тухай ойлголтыг Карл Густав Юнг өөрийн *Man and His Symbols* (1964) бүтээлдээ системтэйгээр тайлбарласан бөгөөд тэрээр архетипийг хамтын ухамсаргүйд⁵ орших, хүний туршлагаас үл хамааран үе дамжин хадгалагддаг сэтгэл зүйн анхдагч дүрслэл, бэлгэдлийн хэлбэр гэж тодорхойлсон. Юнгийн үзлээр архетип нь тодорхой дүрс хэлбэрээр биш, харин бэлгэдлийн потенциал байдлаар оршиж, домог, үлгэр, зүүд, шашин, урлагийн бүтээлээр дамжин материалчлагдан илэрдэг. Иймээс аливаа соёлын дүрслэх урлаг, ялангуяа анхны дүрслэлийн хэлбэрүүд нь хамтын ухамсрын гүн давхаргад орших архетипийн бэлгэдлийн илрэл гэж үзэх боломжтой.

Юнгийн энэхүү сэтгэл зүйн тайлбарыг соёлын онолын түвшинд өргөтгөн авч үзсэн судлаач бол Юрий Лотман юм. Тэрээр *Universe of the Mind* (1990) бүтээлдээ “семиосфер” буюу соёлын тэмдэгт орчны тухай онол дэвшүүлж, соёлыг дотоод код, тэмдэгт системүүдийн нэгдэл хэмээн тодорхойлсон. Лотманы үзлээр соёлын аливаа дүрслэл, текст, бэлгэдэл нь тухайн соёлын семиосфер доторх гүн бүтэц, кодын илэрхийлэл байдаг. Энэ үүднээс авч үзвэл архетип нь зөвхөн сэтгэл зүйн түвшний бус, мөн соёлын кодын түвшний давтагдмал бүтэц юм.

Юнгийн онолоор архетип нь тодорхой дүрс хэлбэр бус, харин бэлгэдлийн потенциал юм. Өөрөөр хэлбэл, архетип нь соёл бүрд өөр өөр хэлбэрээр илэрч болох ч, түүний гүн бүтэц нь нийтлэг хэв шинжийг хадгалдаг. Баатар, эх, сүүдэр, тэнгэрлэг хүч зэрэг архетипүүд дэлхийн олон соёлын домог, дүрслэлд давтагдан илэрдэг нь үүний нотолгоо юм.

Лотманы семиосферийн онолын хүрээнд соёл нь өөрийн дотоод код бүхий тэмдэгт орчин бөгөөд түүний аливаа дүрслэл нь гүн бүтэц, утгын системийг илэрхийлдэг. Иймд архетипийг семиосферийн гүн кодын илэрхийлэл гэж үзэх боломжтой. Энэ огтлолцолд архетип нь сэтгэл зүйн болон соёлын түвшний давхар утгатай болно.

Өмнөд Африкийн хадны зургийн судлаач Дэвид Льюис-Уильямс хадны зургийг тайлбарлахдаа танин мэдэхүйн болон шаманист үзлийн хосолсон тайлбарын загварыг дэвшүүлсэн байдаг. Тэрээр *The Mind in the Cave: Consciousness and the Origins of Art* (2002) бүтээлдээ хадны зургийг зөвхөн ахуйн үйл ажиллагаа, ан агнуурын дүрслэл төдий бус, харин хүний ухамсрын өөрчлөгдсөн төлөв⁶ болон зан үйлийн туршлагатай холбоотой бэлгэдлийн дүрслэл гэж тайлбарласан.

Льюис-Уильямсын үзлээр олон соёлын хадны зурагт давтагдан илрэх геометр хээ, антропоморф, болон зооморф нийлмэл дүрслэл, хөдөлгөөнт композици зэрэг

⁵ Collective unconscious буюу “хамтын ухамсаргүй” нь Карл Густав Юнгийн аналитик сэтгэл судлалын онолын гол ойлголтуудын нэг юм. Юнгийн үзлээр хүний сэтгэл зүй нь зөвхөн хувь хүний туршлагаас бүрдэхгүй бөгөөд бүх хүн төрөлхтөнд нийтлэг өвлөгдөн хадгалагддаг гүн давхар сэтгэл зүйн бүтэц оршдог.

⁶ Altered states of consciousness буюу “ухамсрын өөрчлөгдсөн төлөв” гэдэг нь хүний ердийн сэрүүн ухамсраас өөр сэтгэл зүйн болон мэдрэхүйн төлөвт шилжсэн байдлыг илэрхийлдэг ойлголт юм.

нь шаманист зан үйлийн үеийн танин мэдэхүйн туршлагын дүрслэл байж болох бөгөөд эдгээр нь хүний оюун санааны гүн бүтэцтэй холбоотой архетип шинжтэй дүрсүүдийг илэрхийлдэг. Иймээс хадны зураг нь зөвхөн түүхэн баримт төдийгүй тухайн соёлын ертөнцийг үзэх үзэл, космологийн ойлголт, зан үйлийн туршлагыг илэрхийлсэн бэлгэдлийн систем хэмээн ойлгогдох боломжтой юм.

Энэхүү танин мэдэхүй-шаманист тайлбарын хандлага нь хадны зургийг архетип болон семиотикийн үүднээс судлах онолын үндэслэл болдог. Тиймээс монголын хадны зурагт илрэх зооморф⁷, антропоморф⁸, геометр дүрслэлүүдийг соёлын бэлгэдлийн код болон архетипийн илрэл хэмээн тайлбарлахад энэхүү хандлага онолын чухал суурь болж байна.

Судалгааны арга зүй

Судалгаанд “Түүх-соёлын дүрсийн хэлбэрийн ангилал” аргачлалыг бид зохион хэрэглэж, дараах аргуудыг нэгтгэв. Үүнд:

- Форм-фокус ба морфологийн шинжилгээ
- Визуал-функц-хронологийн ангилал
- Панофскийн гурван шатлал
- Семиотик задлан шинжилгээ⁹ зэрэг.

Судалгаанд монголын хадны зургийн томоохон төвүүд болох **Бичигтийн ам, Сэврэй, Тэвэг уул, Тэхтийн давхац, Үзүүр цохиот** зэрэг зургаан дурсгалыг сонгон авч, тэдгээрт агуулагдах 40 гаруй дүрслэлийн хэлбэрийг морфологийн болон иконологийн аргаар задлан шинжилсэн.

Морфологийн шинжилгээнд зооморф дүрслэл 60%, антропоморф 25%, геометр/абстракт 15%-ийг эзэлж байна.

- Зооморф – амьтан, ан агнуур, хөдөлгөөн: байгаль-амьдралын архетип
- Антропоморф – хүн, зэвсэг, баатарлаг үйл: сүнслэг ба хүчний архетип
- Геометр/абстракт – шугам, долгион, нар: оршихуйн мөчлөгийн архетип

Энэ гурвалсан бүтэц нь Монголын неолит–түрэгийн үеийн дүрслэлийн гүн сэтгэлгээний загварыг илэрхийлэх боломжтой гэж үзэж байна.

Судалгааны үр дүн

Бичигтийн амны хадны зураг. Антропоморф дүрслэлүүд геометр хээ, зэвсгийн дүрслэлтэй хосолсон. Морфологи: босоо төв шугамтай зохиомж, дүрийн хажууд сүлдэн тэмдэг байрласан. Архетипийн холбоос: Хүн – Сүнс – Оршихуй (Зураг 1)

Сэврэй хадны зураг. Морь, шувуу, нарны тэмдэг, долгион хээ зэрэг нийлмэл дүрсүүд тодорхойлогдоно. Морфологи: спираль болон долгион хэлбэрийн зураас давамгай; геометрийн зохиомж өндөр. Архетипийн холбоос: Нар – Ус – Мөчлөг (Зураг 2)

⁷ Зооморф (Zoomorphic / Zoomorphism) гэдэг нь амьтны хэлбэр, шинж, дүр төрхийг ашигласан дүрслэл, бэлгэдэл, эсвэл хүнийг амьтны шинжтэйгээр илэрхийлсэн хэлбэрийг хэлдэг ойлголт юм.

⁸ Антропоморф (Anthropomorphic / Anthropomorphism) гэдэг нь хүний хэлбэр, шинж чанар, үйл хөдлөлийг дүрслэлд ашиглах ойлголт юм.

⁹ Юрий Лотман болон Ролан Барт нарын семиотикийн загварууд нь дүрслэл, тэмдэг, соёлын утгыг тайлбарлахад өргөн хэрэглэгддэг онолын суурь хандлагууд юм.

Тэвэг уулын хадны зураг. Хүн болон тотем амьтан (магадгүй бүргэд эсвэл чоно)-ы нэгдэлтэй дүрслэл; босоо байрлалтай, зүүн гартаа саваа эсвэл тэмдэг барьсан. Морфологи: хагас антропоморф + зооморф нийлмэл дүрс. Архетипийн холбоос: Сүнс – Хүч – Хувирал (Зураг 3).

Тэхтийн давхац хадны зураг. Олон морь, буга, ан агнуурын дүрсүүд. Хөдөлгөөн чиглэлтэй зурлага давамгай. Морфологи: параллель хөдөлгөөнтэй дүрс, анчин – амьтны харьцаа тод. Архетипийн холбоос: Хөдөлгөөн – Хүч – Тэнцвэр (Зураг 4).

Үзүүр цохиотын хадны зураг. Нар, долгион, хөндлөн шугамын хээ давамгай. Морфологи: төвлөрсөн дугуй хэлбэр, радиаль хөдөлгөөн. Архетипийн холбоос: Нар – Оршихуй – Мөнхжил (Зураг 5).

Панофскийн иконологийн шатлалаар хадны зураг нь тухайн нийгмийн гүн ухамсрын бэлгэдэл юм. Үүнд:

- Зооморф дүрслэл – хүч ба байгальтай нэгдсэн “Тэнгэрийн амьтан” архетип,
- Антропоморф дүрслэл – баатарлаг сүнс, нүүдэлч хүний “эр зоригийн” архетип,
- Геометр дүрслэл – нар, мөчлөг, оршихуйн тасралтгүй хөдөлгөөнийг илэрхийлсэн космологийн архетип гэж үзэх санал дэвшүүлж байна.

Эдгээрийн нэгдэл нь Монголын дүрслэлийн хамгийн эртний график хэлний суурь код болох боломжтой юм.

Хэлэлцүүлэг

Монголын хадны зурагт илрэх дүрслэлийн хэлбэрүүдийг ерөнхийд нь зооморф, антропоморф, геометр болон космологийн бэлгэдлийн дөрвөн үндсэн ангилалд хуваан авч үзэж болно. Монголын хадны зурагт илрэх зооморф, антропоморф, геометр дүрслэлүүдийг авч үзвэл, тэдгээр нь зүгээр нэг ахуйн тэмдэглэл бус, харин харилцан уялдаатай бэлгэдлийн бүтэц үүсгэж, нүүдэлчдийн ертөнцийг үзэх үзлийн “хүн – амьтан – тэнгэр” гэсэн гурвалсан загвартай холбогдон илэрдэг. Жишээлбэл:

- **Зооморф дүрслэл** (буга, янгир, адуу, чоно) нь хүч чадал, үржил шим, ан гөрөө, тотемын ухамсрыг илэрхийлэх архетипийн шинжтэй.
- **Антропоморф дүрслэл** (анчин, бүжиглэгч, бөөгийн дүр) нь баатар, зуучлагч, зан үйлийн архетипийг илтгэнэ.
- **Геометр абстракт дүрслэл** (тойрог, нар, хас тэмдэгт бүтэц) нь космологийн дэг журам, тэнгэр-газар-хүн гурвалсан ертөнцийн загварыг бэлгэдэх боломжтой.

Хадны зураг бол зөвхөн уран зураг бус, харин semiotic system – бэлгэдлийн код юм. Монголын хадны зурагт илрэх хөдөлгөөн, давтагдал, хэмнэл нь орчин үеийн график дизайны хэлбэрүүдтэй ижил зарчмаар “visual grammar” буюу хараа зүйн дүрмийг бүрдүүлж байна. Иймээс архетипийн судалгаа зөвхөн археологийн бус, дизайны онолын хувьд ч үндэслэлтэй болох юм.

Энд тодорхойлогдсон “Монголын графикийн архетип” нь:

1. Байгаль – амьтан – хүн – тэнгэрийн уялдаа,
2. Зохиомжийн хэмнэл ба симметри,
3. Хөдөлгөөн, хүчний динамик, гэсэн гурван үндсэн визуал зарчимд тулгуурлаж байгааг бид тогтоолоо.

Ингэснээр хадны зураг нь зөвхөн түүхэн баримт бус, харин тухайн нийгмийн хамтын ухамсрын дотоод бүтэц, соёлын код, архетипийн бэлгэдлийг хадгалсан “анхны текст” болж харагдана. Өөрөөр хэлбэл, Юнгийн онолын сэтгэл зүйн архетип ба Лотманы семиосферийн соёлын код хоёр нь монголын хадны зурагт огтлолцож, бэлгэдлийн гүн бүтэц илэрхийлэгдэж байна гэж дүгнэж болно.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд монголын газар нутагт орших хадны зургаар өгөгдлийн сан үүсгэж, хиймэл оюун ухааны тусламжтайгаар зооформ, антропоморф, геометр/абстракт гэсэн гурван шалгуур үзүүлэлт тавин тооцоолол хийвэл илүү үр дүнд хүрэх боломжтойг олж тогтоолоо. Мөн Д.Цэвээндорж, Х.Пэрлээ, Д.Баяр, Л.Дашням болон бусад судлаачдын туурвисан түүх-археологийн судалгаа, “иконографийн өмнөх тайлбар”-ууд маш том судалгааны суурь болсоныг энд цохон тэмдэглэж байна.

Энэхүү судалгаанд монголын хадны зурагт илрэх архетипийн дүрслэлийн үндсэн хэлбэрүүдийг тодорхойлохыг зорьсон боловч эдгээр дүрслэл нь зөвхөн хадны зурагт хязгаарлагдахгүй, харин нүүдэлчдийн дүрслэлийн соёлын урт хугацааны хөгжлийн эх үндэс болох боломжтой юм. Хадны зурагт илэрсэн амьтан, хүн, космологийн бэлгэдлийн дүрслэлүүд нь хожмын буган хөшөөний иконографи, Евроазийн тал нутгийн амьтны стиль, Хүннүгийн үеийн нэхмэл ба гоёлын хээ, улмаар овог аймгийн тамга тэмдэг зэрэг дүрслэлийн системүүдэд үргэлжлэн илэрч буйг ажиглаж болно. Энэ утгаараа хадны зураг нь нүүдэлчдийн дүрслэлийн хэлний анхны хэлбэрүүдийг хадгалсан эх сурвалж бөгөөд монголын дүрслэлийн соёлын хөгжлийг хадны зураг → буган хөшөө → амьтны стиль → нэхмэл хээ → тамга тэмдэг гэсэн тасралтгүй бэлгэдлийн хувьслын хүрээнд цаашид авч үзэн судлах боломжтой юм

Дүгнэлт

Монголын хадны зурагт суурилсан архетипийн судалгаа нь соёлын язгуур үеийн “график сэтгэлгээ”-г орчин үеийн арга зүйн дагуу дахин тодорхойлж байна. Монголын хадны зурагт давтагдан илрэх архетипийн дүрслэлийн үндсэн ангиллыг харуулсан схемийг Зураг 6-д үзүүлэв. Монголын хадны зурагт илрэх дүрслэлийн хэлбэрүүдийг семиотик болон архетипийн үүднээс ангилан үзэхэд амьтны, хүний, космологийн, геометр/абстракт гэсэн дөрвөн үндсэн архетипийн бүтэц тодорхойлогдож байна. Эдгээр бүтэц нь тусгаарлагдсан бэлгэдэл бус, харин харилцан уялдаатай харааны кодын системийг бүрдүүлж, нүүдэлчдийн ертөнцийг үзэх үзэл, байгаль-хүн-тэнгэрийн харилцааны язгуур сэтгэлгээг илэрхийлж байна.

Энэ нь монголын дүрслэх соёлын уламжлал тасралтгүй хөгжиж ирсэн тухай ойлголтыг архетип болон визуал-семиотикийн үүднээс тайлбарлаж буйгаар онцлогтой. Өөрөөр хэлбэл, хадны зураг дахь дүрслэлүүд нь зөвхөн тухайн цаг үеийн ахуйн тэмдэглэл биш, харин олон үе дамжин давтагдан хадгалагдсан бэлгэдлийн “анхдагч график код” байсан гэж үзэж байна. Эдгээр код нь нүүдэлчдийн соёлын ой санамжид хадгалагдан, дараагийн түүхэн үеүдийн дүрслэх урлаг, төрийн бэлгэдэл, гоёл чимэглэл, бичиг үсгийн хэлбэр, зэвсэг хэрэгслийн чимэглэл зэрэгт өөр өөр хэлбэрээр үргэлжлэн илэрсэн байх боломжтой юм.

Тухайлбал, хадны зурагт түгээмэл тохиолддог буга, янгир, морь, чоно зэрэг зооморф дүрслэлүүд нь хожмын Хүннүгийн “амьтны загварын урлаг” (animal style art)-т илүү боловсронгуй хэлбэрээр үргэлжилж байгааг ажиглаж болно. Хүннүгийн хүрэл эдлэл, гоёл чимэглэл, бүсний арал, зэвсгийн чимэглэлд гардаг амьтдын хөдөлгөөнт, эрч хүчтэй дүрслэл нь хадны зураг дахь хөдөлгөөн давамгайлсан зооморф композициудтай архетипийн түвшинд холбоотой байж болох юм. Энэ нь амьтны дүрслэл нь зөвхөн гоёлын шинжтэй бус, харин хүч чадал, хамгаалалт, овог аймгийн бэлгэдэл, космологийн ойлголтыг илэрхийлсэн архетипийн код байсныг илтгэнэ.

Мөн Түрэгийн үеийн буган чулуун хөшөө, тамга тэмдэг, хадны бичээсүүдэд илрэх нар, тойрог, спираль, тэнхлэгт бүтэц бүхий геометр дүрслэлүүдийг хадны зураг дахь космологийн болон абстракт архетипүүдийн үргэлжлэл гэж үзэх боломжтой. Ялангуяа тэнгэр, нар, хөдөлгөөн, мөчлөгийг илэрхийлсэн дүрслэлүүд нь нүүдэлчдийн ертөнцийг үзэх үзлийн гүн код болж олон зуун жилийн турш хадгалагдсан байж болох юм. Иймээс монголын график соёлын хөгжил нь зөвхөн хэлбэрийн хувьсал бус, харин архетипийн бэлгэдлийн кодын түүхэн шилжилт гэж ойлгогдож байна.

XIII зууны Монголын эзэнт гүрний үеийн дүрслэх урлагт ч энэхүү архетипийн залгамж тодорхой хэмжээнд ажиглагддаг. Тухайлбал, төрийн туг, тамга, зэр зэвсгийн чимэглэл, хаад язгууртны хэрэглэлийн дүрслэлд амьтны хүчирхэг хэлбэр, тэнгэрлэг эрх мэдлийг илтгэх босоо тэнхлэгт бүтэц, нар-сарны бэлгэдэл зэрэг нь хадны зураг дахь космологийн болон амьтны архетипүүдийн уламжлалт үргэлжлэл гэж тайлбарлагдаж болно. Энэ нь нүүдэлчдийн соёл дахь визуал сэтгэлгээ нь үе үеийн улс төр, шашин, нийгмийн өөрчлөлтөд дасан хувирсан ч үндсэн бэлгэдлийн бүтэц нь хадгалагдсаар ирснийг харуулж байна.

Цаашлаад орчин үеийн Монгол Улсын төрийн бэлгэдэл, соёмбо тэмдэг, төрийн сүлд, уламжлалт хээ угалз, үндэсний дизайны элементүүдэд хүртэл энэхүү архетипийн код тодорхой хэмжээнд оршин байгааг ажиглаж болно. Жишээлбэл, соёмбо тэмдэг дэх нар, сар, галын дүрслэл нь космологийн архетипийн үргэлжлэл болно. Харин морь, чоно, бүргэд зэрэг амьтны дүрслэлүүд нь хүч чадал, эрх чөлөө, хамгаалалтын архетипийн уламжлалыг хадгалсан хэвээр байна. Энэ утгаараа монголын орчин үеийн визуал соёл нь эртний хадны зурагтай шууд бус боловч гүн бүтцийн холбоотой гэж үзэх боломжтой юм.


Ийнхүү монголын хадны зураг нь зөвхөн археологийн дурсгал бус, харин монголын дүрслэх соёлын хамгийн эртний “визуал санах ой” гэж ойлгогдож байна. Тэнд бүрэлдсэн график архетипүүд нь олон мянган жилийн турш соёлын дотоод код болон хадгалагдаж, нүүдэлчдийн ертөнцийг үзэх үзэл, зан үйл, төрийн бэлгэдэл, урлагийн хэлбэрүүдэд өөр өөр цаг үед дахин дахин материалчлагдсан гэж үзэж болох юм. Иймээс монголын хадны зураг нь монголын график сэтгэлгээний анхдагч суурь төдийгүй, үндэсний визуал идентификацийн гүн архетипийн эх сурвалж мөн гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Ашигласан материалын жагсаалт

- Баяр, Д. 2015. *Ноён уулын малтлага: Хүн чулуу ба буган хөшөө*. Улаанбаатар: ШУА Пресс.
- Цэвээндорж, Д. 2010. *Хадны зураг ба эртний урлагууд*. Улаанбаатар: Археологийн хүрээлэн.
- Гонгоржав, Г. 2018. *Төв Азийн хадны сүг зургийн урлаг*. Улаанбаатар: Төрийн хэвлэлийн газар.
- Дашням, Л. ба бусад. 1999. *Монгол нутаг дахь түүх соёлын дурсгал*. Улаанбаатар.
- Лотман, Ю. 1990. *Оюун санааны ертөнц: Соёлын семиотик онол*. Блүүмингтон: Индианагийн их сургуулийн хэвлэл.
- Пановский, Е. 1955. *Дүрслэх урлаг дахь утга*. Гарден Сити, Нью-Йорк: Даблдэй.
- Юнг, К. Г. 1964. *Хүн ба түүний бэлгэдэл*. Нью Йорк: Даблдэй.
- Lewis-Williams, D. 2002. *Азуй дахь оюун ухаан: Ухамсар ба урлагийн гарал үүсэл*. Лондон: Темза ба Хадсон.




Зураг 1. Бичигтийн амны хадны зураг



Зураг 2. Сэврэй хадны зураг




Зураг 3. Тэвэг уулын хадны зураг



Зураг 4. Тэхтийн давхац хадны зураг



Зураг 5. Үзүүр цохиотын хадны зураг



Зураг 6. Монголын хадны зургийн архетипийн ангиллын загвар